

Е.Батчулуун, Г.Баярмаа, Θ.Болорчимэг,  
Э.Мөнгөнтулга, Р.Нямхүү, Т.Оюун,  
У.Туяа, М.Энхбаяр, А.Энхтогтох

# ХҮН БА ОРЧИН



Ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн сурх бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
Х-822

Хүн ба орчин II: Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангийн сурх бичиг /  
Энхтогтох А., ба бус; Ред. Цэцэгмаа Г. -УБ. 2014.-76x./

Энэхүү сурх бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурх бичгийн талаарх аливаа санал, хүснэгтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99973-69-45-1

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	4
<b>ӨӨРИЙГӨӨ МЭДҮЕ .....</b>	<b>5</b>
Бидний бие .....	6
Миний хичээлийн хэрэглэл .....	10
Бид юу сурсан вэ? .....	12
<b>ХАРИЛЦЬЯ, ХАМТАРЬЯ .....</b>	<b>11</b>
Манай гэрийнхэн .....	12
Миний гэр орон .....	16
Бид юу сурсан бэ? .....	18
<b>СУРГУУЛЬТАЙГАА ТАНИЛЦЬЯ .....</b>	<b>19</b>
Сургуулийн гадаад орчин .....	20
Сургуулийн дотоод орчин .....	23
Бид юу сурсан вэ? .....	32
<b>ОРЧНОО АЖИГЛАЖ, СУДАЛЬЯ .....</b>	<b>33</b>
Орон нутаг ба хүмүүс .....	34
Орон нутаг ба байгаль .....	40
Бид юу сурсан вэ? .....	46
<b>БАЙГАЛИЙН ҮЗЭГДЛИЙГ АЖИГЛАЯ .....</b>	<b>47</b>
Гэрэл ба харанхуй .....	48
Гэрэл ба сүүдэр .....	50
Өдөр ба шөнө .....	56
Сар ба улирал .....	60
Бид юу сурсан вэ? .....	70

## ӨМНӨХ ҮГ

Хүүхдүүд ээ! Та нарт хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Энэ хичээлийн жилд та нар “Хүн ба орчин” хичээлээр

- Байгаль, нийгмийн юмс үзэгдлийг сонирхон судлах;
- Бусадтай харилцах;
- Эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, чадвар эзэмшиж зөв дадал хэвшилд суралцах болно.

Үүний тулд:

1. Юмс үзэгдлийг ажиглах, асуулт асуух, таамаглал дэвшүүлэх
2. Юуг, яаж судлахаа төлөвлөх, тэмдэглэл хөтлөх
3. Даасгал, даалгавар, сорилт туршилтыг хийж гүйцэтгэх
4. Хийсэн ажлынхаа үр дүнг бусдадаа танилцуулж тайлбарлах гэсэн сурах арга барилын дөрвөн үйлд шатлан суралцана.

### ТАНИХ ТЭМДЭГ



Судлах зүйлийн талаар асуулт асуух,  
таамаглал дэвшүүлэх



Юуг, яаж судлахаа төлөвлөж тэмдэглэл  
хөтлөх



Төлөвлөсний дагуу даасгал, даалгавар, сорилт  
туршилт хийх



Хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулах

# ӨӨРИЙГӨӨ МЭДЬЕ



Миний хичээлийн хэрэглэл  
Бидний бие  
Бид юу сурсан бэ?

## БИДНИЙ БИЕ

### БИЕИЙН БҮТЦИЙН ХЭСГИЙГ СУДАЛЬЯ



Дэлхийн хүүхдүүд ялгаатай байна уу? Ялгаатай шинжүүдийг ✓ гэж тэмдэглэе.




- Үсний өнгө
- Нүдний өнгө
- Биеийн бүтцийн хэсгүүд (толгой, их бие, дээд, доод мөч)
- Арьсны өнгө



Бид юугаараа ялгаатай, юугаараа ижил болохыг судалцгаая.




**Дасгал 1.** Биеийн бүтцийн хэсгүүдийг ажиглаарай. Юу гэж нэрлэдэг вэ?  
Дэвтэртээ бичээрэй.



## БИДНИЙ БИЕ

**Дасгал 2.** Толгойн хэсэгт юу байгааг нэрлээд, тэдгээрийн үүргийн талаар ярилцаарай.



**Дасгал 3.** Бидний нүд ямар хэсгүүдээс бүрддэг вэ? Өөрийн бие болон зурагт зааж нэрлээд, үүргийг нь дэвтэртээ бичээрэй.



Нүд ..... үүрэгтэй.  
Зовхи ..... үүрэгтэй.

Хөмсөг ..... үүрэгтэй.  
Сормуус ..... үүрэгтэй.

**Дасгал 4.** Ном уншиж, бичиж байхад нүд амархан ядардаг. Иймээс 25-30 минут тутам нүдээ амраах дасгал хийгээрэй.

1. Нүдээ аниад, нээнэ.
2. Нүдээ дээш, доош, баруун, зүүн тийш эргүүлнэ.
3. Цонхоор алсын зүйлс харна.

**Дасгал 5.** Чи нүдээ яаж хамгаалдаг вэ? Бичээрэй.

1. Компьютер тоглохдоо
2. Зурагт үзэхдээ
3. Салхи, шороотой үед
4. Хурц гэрлээс

Найз нөхөдтэйгээ тоглохдоо хальтарч унах буюу толгой, гар, хөлөө гэмтээж, бэртэхээс хамгаалж анхаарал, болгоомжтой байх хэрэгтэй.



Хүний бие нь толгой, их бие, дээд, доод мөч гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Бидний нүд орчин тойрны юмсыг харж мэдэрдэг. Харин нүдийг тойрсон хэсгүүд түүнийг хамгаалах үүрэгтэй.

## БИДНИЙ БИЕ

### АЖИГЛАЯ, МЭДЬЕ




Их бие, гар хөл ямар үүрэгтэй вэ? Ажиглаж судалъя.



Өөрийн бие буюу зургийг ажиглаад, биед гарч байгаа өөрчлөлтийг мэдье.



**Дасгал 1.** Зургийг ажиглаад биеийн аль хэсэгт, юунаас шалтгаалан өөрчлөлт гарч байгааг ярилцаарай.



Сурагч бүр сандал дээр цэх сууж ном уншиж,  
бичих зөв дадлыг хэвшүүлье.



**Дасгал 2.** Гар, хөлийн хуруунууд ялгаатай юу?

	Гар	Хөл
Адил шинж		
Ялгаатай шинж		

- Гар хөлийн адил ба ялгаатай шинжийг ярилцаад хүснэгтэд тэмдэглээрэй.
- Гарын эрхий хуруу бусад 4 хурууны эсрэг байрласан байдгийн учрыг тайлбарлаарай.
- Бугуйн ба шагайн үеийг зурагт заагаарай.



**Дасгал 3.** Гарынхаа хурууны үеийг тоолоорой. Үе ямар үүрэгтэй вэ?  
Ярилцаарай.

**Дасгал 4.** Бичих, цаас базах, цаас хайчлах зэрэг үйлийг хийхэд аль хуруунууд хэрхэн оролцож байгааг тэмдэглээрэй.



**Дасгал 5.** “Таван хуруугаа нэрлэе” дуут тоглоом тоглоорой.


1. .... Эрхий мэргэн
2. .... Дугар зайсан
3. .... Эмч домч
4. .... Чигчий бүүвэй
5. .... Дунд ноён



**Дасгал 6.** Зургийг ажиглаад бидний хөл ямар үүрэгтэй болох талаар ярилцаарай.



**Дасгал 7.** Танай ангийн ижил өндөртэй эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийн биеийн жин, цээж, бүсэлхий, таазны тойрог ижил болов уу? Таамаглал дэвшүүлээд батлаарай.




- A - Цээжний тойрог  
Б - Бүсэлхийн тойрог  
В - Таазны тойрог



Нуруу нь биед тулгуурын үүрэгтэй. Бид биээ эгц цэх авч явах нь гоё сайхан харагдахаас гадна биеийн хөгжилд нөлөөлнө. Бидний гар хөдөлгөөн хийж хөдөлмөр эрхлэхэд оролцдог. Хөл нь алхах, гүйх, үсрэх, харайх хөдөлгөөнд оролцохоос гадна түшиг тулгуурын үүрэгтэй. Хүний биеийн өсөлт ялгаатай байдаг.

## МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

### ЗӨВ ХЭРЭГЛЭЭРЭЙ



Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийсэн талаар ярилцаж дэвтэртээ ангилан бичээрэй.

Юугаар хийсэн бэ?

Модоор

Төмрөөр

Даавуугаар

Цасаар

Хуванцраар

Ширээний тавцан

.....  
.....

Ширээний хөл

.....  
.....

Самбарын алчуур

.....  
.....

Үзүүлэн

.....  
.....



Самбар

.....  
.....




**Дасгал 1.** Ямар шинж чанартай болохыг судалцаа.

Багш самбарт үзүүлэнг дараах 3 аргаар тогтоосон байна. Ангийн самбарыг юугаар хийсэн болохыг тайлбарлаарай.




## МИНИЙ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ


**Дасгал 2.** Гурван шилэн тавганд дэвтрийн цаас, уугч цаас, шохойтой хатуу цаас тавиад нэг дусал ус дусааж ажиглаарай. Ямар цаасаар нь номын хавтас ба үзүүлэнг хийхэд тохиромжтой байх талаар саналаа хэлээрэй.



Дэвтрийн цаас



Уугч цаас



Шохойтой цаас

**Дасгал 3.** Самбарын алчуурыг ямар материалыар хийвэл тохиромжтой байх вэ?

- A. Капрон
- B. Хөвөн давуу
- C. Ноосон даавуу

**Дасгал 4.** Дараах 2 баганад өгөгдсөн зүйлийг уншаад зөв харгалзуулж, яагаад ийм сонголт хийснээ тайлбарлаарай.

- |                |                                     |
|----------------|-------------------------------------|
| 1. Ном, дэвтэр | a. Хүчтэй дарж, хугалж болохгүй.    |
| 2. Цүнх        | b. Иш талаар нь дамжуулна.          |
| 3. Шугам       | c. Ус хүргэж болохгүй.              |
| 4. Үзэг        | d. Угааж, цэвэрлэж хэрэглэнэ.       |
| 5. Хайч        | e. Таглааг нь заавал хийж хадгална. |

**Дасгал 5.** Энэ 2 шугам хуванцраар хийгдсэн.

Батын шугам нугардаг, уян хатан

Харин миний шугам хатуу



Хуванцар бол ..... шинж чанартай.



Бидний хэрэглэдэг сургалтын хэрэглэгдэхүүнийг янз бүрийн материалыар хийсэн тул хатуу бат бөх, зөөлөн хэврэг, уян хатан, ус шингээдэг ба шингээдэггүй, соронзлогдог гэх мэт өөр өөр шинж чанартай байдаг. Бид материалын шинж чанарыг судалж мэдсэнээр сургалтын хэрэглэгдэхүүнээ хэрхэн хэрэглэх, хадгалах аргаа зөв төлөвлөж сурна.

## БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Орон орны хүүхдүүдийн зургийг ажиглаад төсөөтэй ба ялгаатай зүйлийг ангилан бичээрэй.



Нэрлэж бичье.

Төсөөтэй	Ялгаатай

2. Өөрийнхөө гарын зургийг зурж хуруунуудаа нэрлээрэй.



3. Гар, хөлийн ариун цэвэр сахихын ач тус юу вэ? Бичээрэй.

4. Цүнхэндээ байгаа хичээлийн хэрэглэлүүдээ гаргаад юугаар хийсэн, ямар шинж чанартай болохыг хүснэгтэд тэмдэглээд “зөв сонголт”, “зөв хэрэглээ” -ний талаар хэлэлцүүлэг хийгээрэй.

Хичээлийн хэрэглэл	Юугаар хийсэн бэ?	Ямар шинж чанартай вэ?

5. Ширээний гэрэлд бүрхүүл хийх нь нүдний хараанд нөлөөлнө.


а. Тийм                                  б. Үгүй                                  в. Мэдэхгүй

6. Буруу суух нь хүний биед ямар нөлөө үзүүлэх вэ? Бичээрэй

1. .....  
2. .....  
3. .....

||

# ХАРИЛЦЪЯ, ХАМТАРЪЯ



Манай гэрийнхэн

Миний гэр орон


Бид юу сурсан бэ?

## МАНАЙ ГЭРИЙНХЭН


### ХҮНДЛЭХ ЁС



Гэрийнхнээ танилцуулж ярилцацгаая.



Мэдээлэл цуглуулья.



Асуултын дагуу ярилцъя.

- Танай ам бүл хэд вэ?
- Чи хэнтэй амьдардаг вэ?
- Гэр бүлийн чинь хүндтэй хүн нь хэн бэ?
- Танай гэр бүл ямар ёс заншлыг эрхэмлэдэг бэ?



**Дасгал 1.** “Манай гэрийнхэн” мэдээллээ найз нөхдөдөө танилцуулаарай.

**Дасгал 2.** “Манай гэрийнхэн” зурагт цомог бэлтгэж, найз нөхдөдөө танилцуулаарай.

Манай өвөө “Ургийн бичиг” номоо бидэнд өгсөн.  
Ургийн бичгийг яаж хөтлөх бэ?



**Дасгал 3.** Авга, нагац гэж ямар хүмүүсийг хэлэх вэ? Төрөл садныхаа ахмад хүмүүсийг авгайлан дууддаг нэрийг бичээд ярилцаарай.

**Миний авга**

Миний аавын дүүг ..... гэдэг. Би ..... гэж  
дууддаг. Аавийн эгчийг ..... гэдэг. Бид .....  
гэж авгайлан нэрлэдэг.


**Миний нагац**

Миний ээжийн ахыг ..... гэдэг. Бид .....  
гэж авгайлдаг. Ээжийн эгчийг ..... гэдэг. Би  
..... гэж авгайлан хүндэлдэг.

**Дасгал 4.** Бэлтгэсэн мэдээллээ ашиглан асуултад хариулж дэвтэртээ бичээд, наиз нөхдөдөө уншиж өгөөрэй.

1. Аавынхаа өвөг эцэг, эмэг эхийнхээ нэрийг бичнэ үү.
2. Ээжийнхээ өвөг эцэг, эмэг эхийнхээ нэрийг бичнэ үү.

**Дасгал 5.** Гэр бүлийнхэнийхээ зургыг дараах загварыг ашиглан модны мөчир хэлбэрээр зураглаж, танилцуулга бэлтгээрэй.



Аав, ээжийн ах, эгч, дүүг төрөл садан гэнэ. Аавын төрөл саданг авга, ээжийн төрөл саданг нагац гэнэ. Манай гэрийнхэн авга, нагац ах эгчээ авгайлан дуудаж хүндэтгэдэг ёс заншилтай.

## МИНИЙ ГЭР ОРОН

### МЭДЭЖ АВЬЯ, БУСДАД ТУСАЛЬЯ



Бид хэн нэгэнд яаралтай тусламж үзүүлэх асуудал гарч ирдэг. Ийм үед хэнд хандах вэ?

Хамтран судалж мэдэж авъя.



Нэн шаардлагатай утасны дугаарыг мэдэхийн ач тус юу вэ? Ярилцъя.



**Дасгал 1.** Бүх нийтээр заавал мэдэх шаардлагатай утасны дугаарыг нэрлэж бичээрэй.

1. .... 2. .... 3. ....

**Дасгал 2.** Дараах таних тэмдгийн учрыг тайлбарлаж, утасны дугаарыг бичээрэй.



**Дасгал 3.** Ямар тохиолдолд утасдах вэ? Тайлбарлаарай.



**Дасгал 4.** Цагдаа, түргэн тусламж, галын машин дуут дохио хэрэглэдгийн учир юу вэ? Ярилцаарай.



Зөвхөн гол түймэр, осол гэмтэл гарсан тохиолдолд л утасдахыг анхаарна уу!




Өөртөө болон бусдад яаралтай тусламж үзүүлэх нь бидний үүрэг юм.

## ГЭР БА СУРГУУЛЬ ОРЧИМ



Болдын наиз Маргад Японд амьдардаг. Саяхан Маргад сургууль орчмынхоо зургийг Болдод илгээжээ.



Маргад сургууль орчмынхоо зүйлсийг хэрхэн тэмдэглэсэн байгааг ажиглаарай. Тэдний сургуулийн орчин дахь зүйлсийг нэрлээрэй.

Хэрэв сургуулийн хашааны өмнө талын хаалгаар орвол:

- Хөл бөмбөгийн талбай руу явахын тулд аль зүг рүү эргэх вэ?
- Амрах сандалд хүрэхийн тулд аль зүг рүү явах вэ?
- Усан сэлэлтийн газар аль зүгт байна вэ?
- Зайрмаг худалдан авахын тулд аль зүг рүү явах вэ?
- Хоёр хэсэг газар байгаа модод аль зүгт байна вэ?



**Дасгал 1.** Хэрэв чи найздаа өөрийн гэрийн ойр орчмыг зурж, захидал илгээх бол хэрхэн дүрслэх вэ? Маргадын зурсан шиг гэр орчмын зургийг дэвтэртээ зураарай.

**Дасгал 2.** Гэр ба сургуулийнхаа ойр орчимд байгаа юмсыг ажиглаад нэрлээрэй.

Ойр орчимд уул, ой мод, худаг, зам, гудамж, гүүр, талбай, байшин барилга бий юу? Алиных нь нэрийг чи мэддэг бэ? Жагсаан бичээрэй. Жишээ нь: Эмнэлэг, Хайрхан уул, Дэрстэй булаг гэх мэт.


1. Уулын нэр: .....
2. Голын нэр: .....
3. Байгууллагын нэр: .....
4. Дэлгүүрийн нэр: .....

**Дасгал 3.** Гэр ба сургуулийн хаана тоглоомын талбай ба ногоон байгууламж байгааг ажиглаад зүг чигийг зааж зураарай.

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

### БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Дараах загварыг ашиглан түрван үеийн нэрийг бичээрэй.




2. Авга, нагац гэж ямар хүмүүсийг хэлэх вэ? Цэгийн оронд бичээрэй.

..... авга, ..... нагац гэнэ.

3. Зүг чигийн товчилсон нэрийг гүйцээн бичээрэй.

- a. БӨ - .....  
b. ЗХ - .....  
c. ЗӨ - .....  
d. БХ - .....

4. Найзынхаа гэр байгаа зүгийг үндсэн ба завсрын зүгийг заасан зураг ашиглан олоорой.



5. Зургийг ажиглаад зөв харгалзуулан холбоно уу.



102



103



101



.....  
.....  
.....  
.....

7. Хэрвээ та осол гэмтэл гаралгүй тохиолдолд худал дуудлага өгч утасдвал бусдад ямар хохирол учруулж болзошгүй вэ? Өөрийн бодлоо бичээрэй.

8. Манай гэрийн хойд зүгт уул, өмнө зүгт нуур, зүүн зүгт толгод, баруун зүгт гол урсдаг гэж Болд ярив. Болдын гэрийн эргэн тойрныг дэвтэртээ зураарай.

III


# СУРГУУЛЬТАЙГАА ТАНИЛЦЪЯ



Сургуулийн гадаад орчин  
Сургуулийн дотоод орчин  
Бид юу сурсан бэ?

## СУРГУУЛИЙН ГАДААД ОРЧИН

### СУРГУУЛЬ ХААНА БАЙНА ВЭ?



Бид өмнөх ангидаа хойд, өмнө ба баруун зүүн зүгийг тодорхойлж чаддаг болсон. Зургийг ажиглаарай. Зүгийг бас нарийвчлан завсрлын зүгээр хэрхэн тодорхойлсныг ярилцаарай. Завсрлын зүгийг нэрлэж сурцгаая.

**Дасгал1.** Баруун хойд (БХ), зүүн хойд (3Х), баруун өмнө (БӨ), зүүн өмнө (3Ө) зүгийг хэрхэн тодорхойлж болох вэ? Дараах асуултад хариулж бичээрэй.

1. .... ба ..... зүгийн хооронд баруун хойд;
2. .... ба ..... зүгийн хооронд баруун өмнө;
3. .... ба ..... зүгийн хооронд зүүн хойд;
4. .... ба ..... зүгийн хооронд зүүн өмнө

**Дасгал 2.** Сургуулийн байшин хаана оршиж байна вэ? Хоосон зайд тохирох зүгийг нэрлэн бичээрэй.



1. Сургууль дэлгүүрийн ..... талд байна.
2. Сургууль номын сангийн ..... талд байна.
3. Манай гэр эмнэлгийн ..... талд байна.
4. Сургууль манай гэрийн ..... талд байна.
5. Дэлгүүрийн хойно ..... байна.

## ДУУ ЯЖ ҮҮСЭХ ВЭ?



Бидний эргэн тойронд ямар дуу чимээ гарч байгааг мэдэрцгээ. Нүдээ аниад хэдэн минут сонсоорой.



Дараа нь юу мэдэрсэнээ бичээрэй. Хэн олон янзын дуу сонссон бэ?

- Сургуулийн аль хэсэгт дуу чимээ их байна вэ?
- Дуу гаргаж байгаа ямар биеуд байна вэ? Нэрлээрэй.
- Ямар дуу хамгийн чанга сонсогдож байсан вэ?



### Туршилт 1



Бөмбөр цохих үед  
цаас хэрхэн хөдлөх вэ?



Утсанд хүрэхэд гарт  
юу мэдрэгдэх вэ?



Резин утсыг хөдөлгөхөд юуг  
мэдэрсэн бэ?



Хөгжмийн дуу хаана сул, хаана чанга  
сонсогдож байна вэ?

### Туршилт 2

Ялгаатай байна уу?



a.



б.



в.

## СУРГУУЛИЙН ГАДААД ОРЧИН

### Туршилт 3

Ширээн дээр хатуу зүйлээр тогшоод сонсоорой. Дараа нь тогших явцад ширээнд чихээ наагаад дахин сонсоорой. Ялгаатай байна уу?



### Дасгал 1. Өгүүлбэрийг уншаад үнэн худлыг тогтоо.

- Дуу гарах үед түүнээс хол байхад сайн сонсогдоно.
- Дуу чичирхийллээр дамждаг.
- Бид дууг хардаг.
- Дуу хамар луу орохоор бид сонсдог.
- Дуу гарах үед түүнд ойрхон байхад сайн сонсогдоно.

### Дасгал 2. Гудамжинд дуу гаргаж байгаа ямар, ямар зүйл байна вэ?

Ямар дуу сул сонсогдож байна вэ? (Таван жишээ бич)


Ямар дуу чанга сонсогдож байна вэ? (Таван жишээ бич)

### Дасгал 3. Хөдөө явж байхад ямар дуу илүү их сонсогддог вэ? Харин хотод ямар дуу их сонсогддог вэ? Жишээ бичээрэй.

### Дасгал 4. Ямар зүйлийн гаргаж байгаа дуу сонсоход хэцүү байдаг вэ?

### Дасгал 5. Их дуу чимээтэй газар ажиллаж байгаа хүмүүс чихэвч зүүх шаардлагатай байдаг. Яагаад гэдгийг тайлбарлаарай.

### Дасгал 6. Дараах амьтад ямар дуу гаргадаг вэ?



### Дасгал 7. Бидний эргэн тойронд байгаа дуу чимээ гэсэн сэдвээр зохиомж хийж найзууддаа уншиж өгөөрэй.



Чичирхийлэн хөдөлж байгаа бие дуу үүсгэдэг. Дуу чимээ гаргаж байгаа биеүдийг дуу үүсгэгч, дууг мэдэрч сонсож байгаа биеийг дуу хүлээн авагч гэнэ. Хэт чанга дуу чимээг удаан сонсоход чих гэмтэж болно.

## ХЭНИЙ ЗӨВ БЭ?



Зурагт байгаа ялгаатай үйлдлүүдийг ажиглаарай.



- Хаана юуг хийж болох вэ? Хаана юуг хийж болохгүй вэ?
- Хэн хэнд тусалж байна вэ?
- Хүүхдүүдийн хийх дуртай зүйл бусдад саад учруулж байна уу?
- Та нарын хийх дуртай зүйл бусдад саад учруулбал яах ёстой вэ?



**Дасгал 1.** Өөрийнхөө хийж чадах зөв гэж үзсэн үйлдлүүдээсээ 2-3-ыг сонгон бичээрэй.

.....

.....



Хүүхэд бүрт өөр өөр сонирхол хэрэгцээ байдаг. Би сонирхсон зүйлээ хийхийг хүсдэг ч бусдыг хүндэтгэх хэрэгтэй. Та нар дуртай зүйлээ хийхийг хүсч байгаа бол бусдад саад болох эсэхийг тунгаан бодоорой.

## СУРГУУЛИЙН ДОТООД ОРЧИН

### БИ ТУСЛАХ УУ?



Би өнөөдөр жижүүр хийнэ. Юу хийх вэ?




Хийх ажлаа төлөвлөе.

- Салхивч нээж агаар оруулъя.
- Ус, алчуур савангаа бэлтгэе.



**Дасгал 1.** Дараах зургуудыг анхааралтай ажиглаад асуултын дагуу ярилцаарай.



1

- Жижүүр охинд юу бодогдсон бэ?
- Хүү ямар шийдвэр гаргасан бэ?
- Тэд ямар үр дунд хүрсэн бэ?



2

Би туслах уу? Ганцаараа хийх амаргүй шүү дээ.



3

Ганцаараа цэвэрлэсэн бол мөд дуусахгүй байх даа...  
Бас ядрах байсан шүү...



4

Найздаа баярлалаа. Чи туслаагүй бол би ганцаараа хэцүү байх байлаа.



**Дасгал 2.** Чамд хэн нэгэн найз чинь тусалж байсан бол баярласан сэтгэлээ бичгээр буюу зургаар илэрхийлнэ үү.

Аливаа зүйлийг хамтарч хийснээрээ амжилтад хүрдэг. Хэн нэг нь танаас тусламж хүсээгүй байхад туслах нь сайхан сэтгэл юм.

## ТАСАЛГААНЫ УРГАМЛЫГ ТАНЬДАГ БОЛЬЁ



Өрөө тасалгаанд  
яагаад ургамал  
тарьдаг юм бэ?



Гоо зүйн мэдрэмж  
төрүүлнэ.

Агаарыг  
цэвэршүүлнэ.

Тоос шороог багасгана.  
Дуу чимээг бууруулна.

Сэтгэл санааг  
тайвшруулна.

Тасалгааны агаарыг  
чийгшүүлнэ.

Өвчин үүсгэгч нянг  
устгана.



Дараах тасалгааны ургамлын зургийг ажиглаад танай анги болон сургуульд  
байгаа бол ✓, үгүй бол ✗ тэмдэглэгээ тавиарай. Зөв нэрлэж сураарай.



Шимтэглэй



Гундаахай



Зунаст



Авиргана



Алаг цэцэг



Гоёмсог сүүт



Арш



Багцхан



Цэгцүүхэй



Судалтод



Хэрээнүд




Ороогуулгана

## СУРГУУЛИЙН ДОТООД ОРЧИН



**Дасгал 1.** Дээрх тасалгааны ургамлыг ургах байдлыг ажиглаж доорх дөрвөн бүлэгт ангилан бичнэ үү. Мөн өөрсдийн мэддэг болон анги, гэртээ байдаг ургамлын нэрийг нэмж бичээрэй.



## УРГАМАЛД АРЧИЛГАА ЯАГААД ЧУХАЛ ВЭ?




Тасалгааны ургамлыг арчлахын тулд ямар багаж хэрэгсэл бэлтгэх хэрэгтэй вэ?

Усалгааны сав



Энгийн багаж хэрэгсэл



## СУРГУУЛИЙН ДОТООД ОРЧИН



Ургамлын онцлогт тохируулан арчлах аргыг хамтран судалцгаая !

- Цэцэглэлтийн явцад нь цэцэг бундууг гөвөхөөс сэргийлж нэг байрнаас нөгөөд шилжүүлж хөдөлгөхгүй байх, шаардлагатай бол болгоомжтой хөдөлгөнө.
- Цэцэглэлтийн үед тасалгааны ургамлыг шилжүүлэн суулгаж болохгүй бөгөөд хэрвээ шаардлагатай бол хөрстэй нь хамт шилжүүлэн суулгана.
- Цэцэглэхээс өмнө бага, цэцэглэсний дараа ахиухан усална.



Гоёмсог  
цэцэглэдэг  
ургамал

- Хатаж хөгширсөн навчийг тасалж цэвэрлэнэ.
- Удумбор зэрэг том, хатуу гадаргуу бүхий навчтай ургамлын тоос шороог чийгтэй зөөлөн алчуураар арчиж цэвэрлэнэ.
- Үслэг навчтай ургамлын навчийг ус хүргэхгүй бөгөөд багс ашиглан болгоомжтой цэвэрлэнэ.
- Үслэг биш, зөөлөн навчтай ургамлыг бүлээн усаар шүрших буюу зайлж угаана.



Гоёмсог  
навчтай  
ургамал

- Шүүслэг навчтай ургамал өөртөө ихээхэн хэмжээний усыг нөөцөлсөн байдаг тул бага услах. Хөрсийг чийгтэй эсэхийг шалгаж 7 хоногт 1 удаа байхаар усалгааг тохируулна.
- Ихээр усалбал ургамал ялзрах аюултай.



Шүүслэг  
навчтай  
ургамал

- Иш нь уян налархай тул савыг нь хананд өлгөх буюу хөрсийг хучих хэлбэрээр ургуулна.
- Жил болгоны хавар ишийн үзүүрээс тайрах буюу дээш авируулах байдлаар ургуулна.
- Навчийг байнга шүршиж услах хэрэгтэй.



Унжиж  
ургадаг  
буюу ороонго  
ургамал

## СУРГУУЛИЙН ДОТООД ОРЧИН



**Дасгал 1.** А эгнээнд өгөгдсөн аргаар Б эгнээний ямар ургамлыг арчилж болохыг холбож заагаад яагаад гэдгийг тайлбарлаарай.

A



Удамбор



Нилцэцэг



Гундаахай

B



Баримагана



Алаг халгай



Мөнхрөө

**Дасгал 2.** Дараах зөвлөмжийг судлаад ангид ургаж байгаа ижил арчилгаа шаардагдах өөр нэг ургамлыг багштайгаа хамтран сонгоорой. Дараа нь хаана байрлуулахаа төлөвлөн арчилгааг тогтмолжуулаарай.

Гэрэлсэг \*

Гэрэлд дуртай \*

Сүүдэрт дуртай ○

Сүүдэрт тэсвэртэй ●



Сарнай



Хайтан



Авиргана



Гоодаль



Тасалгааны ургамал бүрийг сайтар ажиглаж онцлогт нь тохируулан арчлах хэрэгтэй.

## ТАСАЛГААНЫ УРГАМЛЫГ УСЛАХАД ЮУГ АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?



Тасалгааны ургамал услах  
дүрэм байдаг уу?



Ургамал бүр өөр өөр онцлогтой учир тогтсон  
дүрэм байхгүй. Гэхдээ анхаарах зүйл байдгийг  
мартаж болохгүй.



Зөв услаарай.



1. Хөрсийг урсгахгүй савны ирмэг дагуулж усална.
2. Намар цагт нэг өдөр өнжөөд, өвөл түүнээс цөөн, хавар услалтыг нэмэгдүүлж, зун өдөр бүр усална.
3. Хүйтэн усаар услах нь ургамлын үндэсний үйл ажиллагааг зогсоох тул крантны усаар услах бол усыг тасалгаанд 12 цаг байлгана.
4. Сэргүүн өрөөнд байгаа ургамлыг бага услах ба хүйтэн усаар услахгүй.
5. Шинэхэн суулгасан ургамал үндэс багатай тул бага усална.
6. Хэт чийгтэй хөрс ургамлын үндсийг ялзруулдаг тул услалтыг тааруулна.
7. Орчныг шүршиж навчин дээрх тоосыг зайлуулна.
8. Үсэргэг навчтай ургамлыг шүршиж услахгүй.
9. Том савтай ургамлын савыг тогшиж үзэн чийгийн хэмжээг мэдэж болно. Чимээ бөглүү бол хөрс чийгтэй, тод чимээтэй бол хөрс хуурай байна гэсэн үг. Сав бага байх тусам хөрс амархан хатах тул байнга усална.
10. Усалснаас хойш 1-2 цагийн дараа доод тосгуурт ус тунаж байвал илүүдэл усыг муутгаж болохгүй асгана.

## СУРГУУЛИЙН ДОТООД ОРЧИН



**Дасгал 1.** Анги, сургуулийн орчинд болон гэртээ ургасан ургамлын нэр, арчилгааны талаарх зөвлөмжийг бичиж байрлуулаарай.

Ургамлын нэр: .....

Хаана байрлуулах: .....

Яаж услах: .....

**Дасгал 2.** Хүүхэд бүр сонгон авч арчилж байгаа тасалгааны ургамалд ямар өөрчлөлт гарсныг ажиглан тэмдэглэл хөтөлж үр дүнг ангийнхандаа танилцуулаарай.

Тэмдэглэл хөтлөх хуудас:

Тасалгааны ургамлын нэр	Яаж арчилсан бэ? (он сар өдөр)	Услахад юу анхаарах вэ?

Танилцуулах үйл явц.



## СУРАГЧДЫН АМРАЛТААР УРГАМЛАА ХЭРХЭН АРЧЛАХ ВЭ?



Гэр, сургуулиасаа удаан хугацаагаар хол явах бол тарьсан ургамлаа хэрхэн яаж арчлах вэ?



Хэн нэгэнд захиж үлдээнэ.



Өөр аргууд байдаг гэж сонссон, хамтран судалцгаая.

- Өвлийн улиралд ихэнх тасалгааны ургамлуудыг сайн усалж, өрөөний дулааныг багасгаж өгвөл тэр хэдэн долоо хоногоор ч усгүй байж чаддаг.
- Зуны өдрүүдэд орхиж явахаар бол тусгай бэлтгэл хэрэгтэй.



### Туршилт 1

Туршиж үзээд аль нь хэдий хугацаанд тохиромжтой арга болохыг батлаарай.



Ханатал  
услах



Саванд ус  
хийгээд  
шүүрэх  
байдлаар  
байрлуулах



Сайн услаад  
саванд ус  
шингээсэн  
хивсэнцэр  
дээр тавих



Гялгар уут  
ба тунгалаг  
шил саваар  
бүрхэх



Суурь  
тавганд  
ус хийж  
үлдээх

**Дасгал 1.** Та нарт тарьсан ургамлаа эзэнгүй хаяад гэмтээж байсан удаа байгаа юу?


**Дасгал 2.** Зуны улиралд ангидаа тарьсан ургамлыг яаж арчлах талаар ярилцаарай.



Ихэнх ургамал ус дутагдсанаас биш, усалгаа нь ихэдсэнээс болж үхэж болно.

## БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Зурагт байгаа зүг чигийн зургийг ашиглан сургуулийн ойр орчим дахь дуу чимээ ихтэй газрын нэрийг бичээрэй.



2. Гоёмсог навчтай тасалгааны ургамлыг хэрхэн арчлах аргаас 2-3-ыг бичээрэй.

- а. ....
- б. ....
- в. ....

3. Шүүслэг навчтай тасалгааны ургамлыг услахад юу, юуг анхаарах ёстой вэ? Жишээ бичээрэй.

- а. ....
- б. ....
- в. ....


5. Болд тасалгааны ургамлаа ингэж услахаар шийдэв. Яагаад? Тайлбарыг бичээрэй.



.....  
.....  
.....  
.....

IV

# ОРЧИН ТОЙРНОО АЖИГЛАЯ



Орон нутаг ба хүмүүс  
Орон нутаг ба байгаль  
Бид юу сурсан бэ?

## ОРОН НУТГИЙН ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР



Зургийг ажиглаад ярилцаарай. Хүмүүс ямар ажил хөдөлмөр эрхэлж байна вэ?



Эдгээр ажил хөдөлмөрийн онцлог нь юу вэ? Энэ ажлыг хийж буй хүмүүс бидэнд хэрхэн тусалдаг вэ?



**Дасгал 1.** Өөрийн хийх дуртай нэг ажлыг сонгож түүнийхээ тухай юуг сайн мэддэг, юуг мэдэхийг хүсэж байгаа, мэдэж авсан зүйлээ тэмдэглээрэй. Жишээ нь:

Миний сонгосон ажил “Цагаан идээ боловсруулах“

Мэддэг зүйл	Мэдэхийг хүссэн зүйл	Мэдсэн зүйл
<ul style="list-style-type: none"> <li>Сүү хөөрүүлэх</li> <li>Өрөм авах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тараг яаж бүрдэг тухай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хонь, ухэр, ямааны сүүг хөөрүүлнэ.</li> <li>Өрмийг нь авна.</li> <li>Болсон сүүгээ гал дээр 35 хэм орчим бүлээсгээд 10 л сүүнд 150-200 гр хөрөнгө хийж самарна.</li> <li>Халаасан сүүгээ саванд юулээд даавуу бүтээлгээр хучиж тавина.</li> <li>Халуун хүйтнээс хамааран 2-3 цагийн дараа хучлагыг нь авна.</li> </ul>



Хүмүүсийн хөдөлмөрөөр өнөөгийн бидний сайн сайхан амьдрал бий болдог.

**Дасгал 2.** “Хүүхдийн тус” сэдвээр ярилцана уу.

Хот суурин газрын болон хөдөө орон нутгийн хүүхдүүд гэр бүлийнхээ болон аав, ээжийнхээ ажилд хэрхэн, яаж тусалдаг вэ?



**Дасгал 3.** Аав ээждээ тусалж, ажил хөдөлмөр хийснээр бидэнд ямар ач тустай вэ? Дараах санааг гүйцээн тэмдэглэнэ үү.

Үндны усаа авах нь надад ч тустай	Үндны ус авахдаа юуг анхаарахаа би мэднэ	Усны саваа ямар байлгах хэрэгтэйг ч сурсан
<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлгөөн хийх нь эрүүл мэндэд тустай</li> <li>Хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэж авна.</li> <li>.....</li> <li>.....</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Халтиргаа гулгаанаас болгоомжлох</li> <li>Гол, горхийн ус бохирдооос сэргийлэх</li> <li>.....</li> <li>.....</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ус хадгалах сав том амсартай, таглаатай байх</li> <li>Зэвэрдэггүй, зориулалтын материалыар хийгдсэн байх</li> <li>.....</li> <li>.....</li> </ul>



Чиний дотны хүмүүс бол гэр бүлийн гишүүд юм. Хүүхэд бид гэр бүлийн нэг гишүүн учраас гэрийн ажилд оролцно. Ингэснээр бид бие биеэ хайрлан хүндэтгэж, тусалж дэмжин эвтэй найртай амьдардаг. Тэгээд ч бас ажил хийнэ гэдэг ганцхан гэр бүлдээ тусалж байгаа юм биш бидний эрүүл мэндэд ч тустай.

## ХҮМҮҮСИЙН АЖИЛ ХӨДӨЛМӨРИЙН ОНЦЛОГ



Танай орон нутагт ямар үйлдвэр, аж ахуйн газрууд байдаг вэ?

Тэнд ажилладаг хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогтой танилцъя.



За тэгье. Тэгвэл аялалынхаа хөтөлбөрийг боловсруулах уу?



Аялалын хөтөлбөр



A.  
Аялалын зорилго

B.  
Хаашаа явах вэ?

V. Аялалд юу авч явах вэ?

G. Ямар дүрэм баримтлах вэ?

D. Хэнтэй уулзаж мэдээлэл цуглуулах вэ?

E. Бусадад хэрхэн танилцуулах вэ?



### Дасгал 1.

- а. Зорилго: .....
- б. Хаанаас хаана хүрэх, тэнд хүрэхийн тулд хаагуур яаж явах, юугаар явах зэргийг харуулсан зураглал гаргана. Гүйцээгээд зураарай.

Сургууль →



- в. Аялалд юу авч явах вэ? Жагсаан бичээрэй.

- Тэмдэглэлийн дэвтэр
- Аяны хувцас

- .....
- .....
- .....
- .....

г. Ямар дүрэм баримтлах вэ?

- Төлөвлөсөн цагтаа цугларна.
- Хамт олноосоо хоцрохгүй
- .....
- .....

д. Үйлдвэрт очоод хэнтэй уулзаж ямар мэдээлэл цуглуулах вэ?

Хүснэгтийг гүйцээн бичээрэй.

№	Хэнтэй уулзах вэ?	Юу мэдэж авах вэ?
1	Манаач болон жижүүр	Таны ажил хөдөлмөрийн онцлог юу вэ?
2	Үйлдвэрийн дарга	
3	Үйлдвэрийн технологич	
4	Чанарын инженер	
5	Борлуулалтын ажилтан	
6	Хүний нөөцийн мэргэжилтэн	

е. Юу үзэж харснаа бусдад хэрхэн танилцуулах вэ?

Аялалын явцад хөтөлсөн тэмдэглэл, цуглуулсан материал дээрээ тулгуурлан

- Танилцуулга бэлтгэнэ
- Зураг зурна
- Шүлэг зохионо
- Бяцхан ном бүтээнэ
- Бүтээлийн сан хийж үзэсгэлэн гаргана

Тэмдэглэл хөтлөх хуудас:

Ажиглалт	Тэмдэглэл	Олж авсан санаа буюу сэтгэгдэл
Он, сар, өдөр		
Хаана байдаг (аль зүйт, ойр орчим нь юу байдал).		
Ямар үйлдвэр үзсэн.		
Ажил хөдөлмөрийн онцлог юу вэ?		



Хүн бүр эрхэлсэн ажил хөдөлмөртөө дуртай бас чадварлаг байх юм бол  
ажлын үр дүн өндөр, бусдад баяр баясгалан бэлэглэж чадах болно.

## ДОМОГ ТӨРСӨН ТҮҮХ



Миний нэрийг аав ээж өгсөн.  
Уул усны нэрийг хэн өгдөг вэ?



Миний өвөө надад Сутай уулынхаа домгийг ярьж өгсөн.  
Уул, усны нэрийг хүмүүс бид өгдөг юм байна лээ.



Сутай хайрхан уул

### Сутай уул

Манай нутгийнхан мөнх цаст Сутай уулаа "Цаст богд" хэмээн дээдэлдэг. Энэ уулын өвс ногоо нь сайн ургадаг байсан. Тэнд цөөн тооны сарлаг үхэртэй хүмүүс нутаглан суурьшдаг байв. Тэд сүү шимиин арвин элбэгт сайхан амьдардаг байсан учир "Сүүтэй уул" гэж нэрлэж байсан нь он жилүүдийн уртад уулын нэр өөрчлөгдж Сутай гэгдэх болсон домогтой.



### Дасгал 1. Хүүхдүүд ээ!

- Өвөөгийн ярьсан домгоос юу ойлгосноо ярилцаарай.
- Сутай уул аль аймгийн нутагт байдаг вэ?  
Газрын зурагт заагаарай.

### Дасгал 2. Монгол орны газрын зурагт амьдарч буй газар нутгаа заагаарай.



### Дасгал 3. Орон нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт газар, уул, усны домог, түүхийн тухай мэдээлэл цуглуулаарай.

Уул, ус, үзэсгэлэнт  
газрын зургийг олно.



Хэн нэгнээс асууж  
лавлана.

Номын сан орно.



Мэдээлэл цуглуулахдаа дээрх дарааллыг ашиглаарай.



**Дасгал 4.** Уул ус, домог, зан үйл, амьтны тухай уншаад тохирох аймгийн газрын зурагт байрлуулаарай.



Отгон тэнгэр хэмээх нэр нь “Галын хаан, “Анхны эх газар” гэсэн үг ажээ. Отгонтэнгэр уул мөнх цастай томоохон өндөр уул юм.



Хөвсгөл нуур нь дэлхий дээрх хамгийн цэнгэг устай, эртний нууруудын нэг юм. Түүнийг 2 сая гаруй жилийн настай хэмээн тооцоолсон байдаг.



Шонхорын төрлийн шувууд дэлхийн хамгийн хурдан жигүүртэн. Учир нь шонхор цагт 300 км хүртэл хурдлах чадвартай, махчин шувуу.

### Эзж хадны домог

Эрт цагт гурван хөх ямаатай нэгэн эмгэн амьдардаг байжээ. Гурван ямаагаа өвөл зунгүй саадаг тул ямааныхаа сүүгээр амьдарч, тэр байтугай ойр хавийн ядуу зүдүү айлд илүүчилдэг байв. Хүмүүс ихэд баярлан буянт ээжтэйгээ адилтган үзэж “эзж” гэж хүндэтгэн дууддаг байжээ. Тийм байсаар эмээ нэгэн шөнө суугаагаараа таалал төгсөж том чулуу болон хувирсан гэх. Буяныг нь хүртэж байсан нутгийнхан нь ихэд харамсан гашуудаадаа “Эзж хад” хэмээн хүндэтгэн дуудах болжээ. Мөн гурван ямаа нь эзнийхээ хажууд гурван чулуу болон тогтсон гэж домог болгон ярьдаг гэнэ.



Эв мод гэдэг нь монгол оросын хилийн харуулын хүмүүс уулзахдаа авч очин эвийг нь нийлүүлэн үздэг итгэмжлэлийн тэмдэгт мод юм. “Эв модоо” яг дундуур тэмдэгт мод юм. Ингээд орос хүн тус тус хадгалдаг байна. Ихэвчлэн нь цуулж нэг талыг монгол хүн, нөгөөхийг уг хоёр хэсгээ жил бүрийн зуны эх буюу монгол ёсоор ханш нээх өдөр эвээр нь нийлүүлж баяр наадам хийдэг.



Наурызын баярыг “Казах” үндэстнүүд жил болгоны гуравдугаар сарын 22-нд тэмдэглэдэг. Наурызын баяр бол нарны баяр, хаврын баяр гэж билэгшээдэг. Энэ баяр нь “Амьдрал тэтгэх наран ээж минь” хэмээн мандаж буй наранд ёсолж, залбирал үйлдсэнээр эхэлдэг.

## УУЛ ЯМАР ХЭЛБЭРТЭЙ ВЭ?



Та нар ууланд авирч үзсэн үү? Зарим ууланд авирахад амархан, зарим нь хэцүү байдаг. Модтой уул хийцгээе.




### Бэлтгэх зүйл

Картон цаас, баримлын шавар, цаас, өнгийн харандаа



- Баримлын шавраа атгаж зөөлрүүлээрэй.
- Картон цаасныхаа голд тавьж уул хийгээрэй.
- Цаасан дээр мод зурж ногоон өнгөөр бударай.
- Зурсан модоо хайчилж, баримлын шавраар хийсэн уулан дээрээ байрлууларай.


Цаасаа хайчлахдаа хайчийг зөв барьж, болгоомжтой хайчлаарай.





**Дасгал 1.** Хулангийн зурсан зургийг ажиглаарай. Энд ямар зүйлс дүрслэгдсэн байна вэ?

- Зурагт тохирох нэрийг тохируулж бичээрэй



Уул

Тал

Толгод

- Эдгээрийг ямар өнгөөр дүрслэсэн байна вэ? Бичээрэй.

Уулыг ..... өнгөөр

Тал болон толгодыг ..... өнгөөр


Цасыг ..... өнгөөр

Нуур ба голыг ..... өнгөөр дүрсэлжээ.

- Зураг дээр байгаа хоёр уулын нэг нь оройдоо цастай байхад нөгөө нь цасгүй байна. Яагаад вэ?

**Дасгал 2.** Танай орон нутагт байдаг уул ба талыг нэрлэж бичээрэй.

**Дасгал 3.** Зургийг ажиглаад ялгааг ярилцаарай.



Уул эргэн тойрны газраасаа өндөр байдаг. Харин тал газар ерөнхийдөө тэгшивтэр байдаг.

## ОРОН НУТАГ БА БАЙГАЛЬ

### ГОЛ БА НУУР ЯЛГААТАЙ ЮУ?



Дэнжээр дэржигнэнэ Хотгоор  
хоржигноно Тэр юу вэ?

Би таалаа. Тэр бол гол



Нутгийнхаа гол нуурыг танин мэдэцгээе. Хоёр зургийг харьцуулж ажиглаарай.  
Нуур, гол хоёр ямар ялгаатай вэ?



Дасгал 1. Нутгийнхаа гол ба нуурын нэрийг бичээрэй.

Дасгал 2. Зургийг ажиглаад асуултад хариулаарай.



Асуулт	Хариулт
Уулын аль зүгт нуур байна вэ?	
Зураг дээр хэдэн нуур байна вэ?	
Аль нуур нь том бэ?	

**Дасгал 3.** Сургуулийн аль зүгт уул оршиж байна вэ? Уулын аль талд ой модтой байна вэ?




**Дасгал 4.** Зураг дээр ямар зүйлсийг дүрсэлсэн байна вэ? Нэрийг бичээрэй. Эдгээрээс танай нутагт аль нь байдаг вэ? Нэрийг нь мэдэх үү? Бичээрэй.



Нуур, цөөрөм

Далай

Гол



Уул

Толгод

Тал



Хотгор газраар налууг даган урсаж байгаа усыг гол гэнэ.  
Хуурай газрын томоохон хонхорт тогтсон их усыг нуур гэнэ.

## ТЭД ЯАГААД ГОВЬ ЭСВЭЛ ОЙД АМЬДАРДАГ ВЭ?



Манай нутаг говьд оршдог.



Говь гэж ямар газрыг хэлэх вэ?  
Тэнд ямар ургамал, амьтад  
амьдардаг вэ?




### Бэлтгэх зүйл

Монгол орны ургамал, амьтны тархалтыг тэмдэглэх газрын зураг



**Дасгал 1.** Өөрийн төрсөн нутаг монгол орны аль хэсэгт оршдогийг газрын зурагт зааж, байгалийн ямар онцлогтой болох талаар ярилцаарай.




**Дасгал 2.** Дараах амьтад хаана амьдардаг болохыг газрын зурагт байрлуулаарай.



**Дасгал 3.** Тэмээ яагаад говьд амьдардаг вэ?



**Дасгал 4.** Говь ба Хангайн ургамал яагаад ийм ялгаатай байдаг вэ?  
Өөрийнхөө бодож байгааг ярьж бусадтай санал солилцоорой.



**Дасгал 5.** Өөрийн орон нутгийн ургамал, амьтны дасан зохицдолгооны тухай юу мэдэх вэ? Жишээ гаргаж ярилцаарай.



Манай орон хойт хэсгээрээ ой бүхий уулархаг, дунд хэсгээрээ тал хээр, өмнө талаараа элсэрхэг говь цөл бүхий нутагтай бөгөөд тэнд дасан зохицсон ургамал, амьтнаар баялаг билээ. Амьдрах орчиндоо дасан зохицсон амьд бие амьдрах чадвартай.

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

### БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Дараах хүснэгтийн дагуу хүмүүсийн хийдэг ажил хөдөлмөрийг тоочиж бичнэ үү.

#### Мал аж ахуй

1. ....
2. ....
3. ....
4. ....
5. ....

#### Газар тариалан

1. ....
2. ....
3. ....
4. ....
5. ....

2. Зөв харгалзуулан холбоорой.

Отгонтэнгэр хайрхан

Ховд аймаг

Ээж хад

Хөвсгөл аймаг

Сутай хайрхан

Завхан аймаг

Хөвсгөл нуур

Төв аймаг

3. Дараах нэршлийг зургаар илэрхийлээрэй.

#### Ой мод

#### Уул нуурууд

#### Тал газар


4. Гол, нуур хоёрын ялгааг нэг өгүүлбэрээр бичиж, зургаар илэрхийлээрэй.

#### Гол

#### Нуур

V

# БАЙГАЛИЙН ҮЗЭГДЛИЙГ АЖИГЛАЯ



Гэрэл ба харанхуй  
Гэрэл ба сүүдэр  
Өдөр ба шөнө  
Сар ба улирал  
Бид юу сурсан бэ?

## ГЭРЭЛ БА ХАРАНХУЙ

### ГЭРЭЛ БА ХАРАНХУЙ



Би харанхуйгаас  
их айдаг.



Айх хэрэггүй.  
Би чамд туслая



Харанхуйг гэрэлтүүлэхийн тулд эдгээр зүйлсээс алийг нь сонгох хэрэгтэй вэ?



Асаалттай  
гар утас



Бөмбөг



Асаж байгаа  
бамбар



Асаж байгаа  
гар чийдэн



Асаж байгаа  
лаа

Аль нь хамгийн зөв сонголт вэ?



#### Туршилт 1

Яагаад нар бидэнд хэрэгтэй вэ?  
Өөрийн бодлоо найзуудтайгаа  
ярилцаарай.




Эргэн тойрноо судлах нь  
ажиглалтаас эхэлдэг.  
Хүүхдүүд ээ! Нарыг хэрхэн  
ажиглахаа төлөвлөөрэй.

Хүүхдүүд ээ! Нарыг ажиглан судлахдаа хамгаалах шил  
заавал зүүгээрэй. Нарыг удаан харж болохгүй шүү!



**Дасгал 1.** Эргэн тойронд гэрэл  
гаграж байгаа ямар биеүд байгааг  
ажиглаарай. Гэрэл гаргадаг ямар  
зүйлс хаана байх вэ? Зураарай.



## Туршилт 2


Хайрцагт эдгээр зүйлсийг хийв. Хайрцагны нүхээр харахад юу харагдах вэ?

1. Хайрцаг бэлтгэнэ.



Надад юу ч  
харагдахгүй байна.

2. Хайрцагт алим хийнэ.




3. Хайрцагт гар чийдэн хийнэ.



Харах аргыг  
нь олчихлоо



**Дасгал 2.** Дараах зургийг ажиглаад ялгаатай байдлыг тайлбарлаарай.



Гэрэл гаргадаг зүйлсийг гэрэл үүсгэгч гэнэ. Нар бол бидэнд харагддаг хамгийн том гэрэл үүсгэгч юм. Гэрэл гаргадаг зүйл байхгүй бол тэнд харанхуй байдаг. Харанхуйг гэрэлтүүлэхэд гэрэл үүсгэгч хэрэгтэй.

## ГЭРЭЛ БА СҮҮДЭР

### ГЭРЭЛ БА СҮҮДЭР



Сүүдэр яагаад үүсдэг вэ? Найзуудтайгаа ярилцаарай



Сүүдэр хэрхэн үүсэхийг судалцгаая  
**Судалгааг төлөвлөх дараалал**

Сүүдэр хэрхэн үүсдэгийг мэдэхийг хүсэж байна.

Сүүдрээ ажиглая.

Хөдөлгөөнөө өөрчилье.

Сүүдэр юунаас хамаарч байгааг ажиглая.

Олж мэдсэн зүйлээ найзуудтайгаа ярилцъя.




#### Туршилт 1



Сүүдэр үүсэх нь нар ба гэрэл үүсгэгчтэй холбоотой. Үүсч байгаа сүүдэр биеийн хэлбэртэй адил байна.

### Туршилт 2

- Гэрэл үүсгэгч, ямар нэг бие ашиглан дэлгэц дээр сүүдэр үүсгэнэ.
- Дэлгэц дээр юу үүсгэж байгааг ажиглаарай. Шалтгааныг нь ярилцаарай.
- Чийдэн дэлгэц хоёрын хооронд бие байхгүй үед сүүдэр үүсэх үү?



- Дэлгэцийн хойно янз бүрийн бие тавьж үүссэн сүүдрийг найзуудаараа таалгаарай.
- Хэн хамгийн олон биеийн сүүдэр таасан бэ?



### Туршилт 3

Сонирхолтой сүүдэр үүсгэе!

**Хэрэглэгдэхүүнээ бэлтгэцгээ.**

Хайч, чийдэн, зузаан цаас, савх мод бэлэн боллоо.




### Гүйцэтгэх дараалал

- Цаасан дээр дүрсээ зурна.
- Дүрсийн дагуу хайчилна.
- Хайчилсан дүрсээ модон савханд бэхэлнэ.
- Сүүдэр үүсгэн тоглоорой.

## ГЭРЭЛ БА СҮҮДЭР



**Дасгал 1.** Хэн хамгийн сонирхолтой дүрс үүсгэсэн бэ? Үүсгэсэн дүрсээ ашиглан үлгэр зохиогоорой. (Эрт дээр үед тагтаа, туулай, хоёр эвтэй найртай хамт амьдардаг байжээ. Гэтэл нэг өдөр...)




**Дасгал 2. Билгээгийн яриа:**

Хэн нэгэн чамайг үргэлж дагадаг уу? Харин намайг миний сүүдэр үргэлж дагаж байдаг. Би ямар үйлдэл хийнэ, сүүдэр минь намайг дууриадаг. Мөн бид үргэлж зэрэг хөдөлдөг. Хамгийн гоё зүйл бол зарим үед сүүдэр урт болчихдог. Энэ үед би ч бас өндөр болсон юм шиг санагддаг. Нэг удаа үүлтэй бүрхэг өдөр миний сүүдэр надаас нуугдсан байсан. Би сүүдрээ хайгаад олоогүй ....

Билгээгийн яриаг цааш үргэлжлүүлэн ярилцаарай.



**Дасгал 3.** Амьтдад сүүдрээ олоход нь туслаарай.



**Дасгал 4.** Гэрэл ба сүүдэртэй холбоотой ямар оньсого, дуу мэдэх вэ?

**Дасгал 5.** Дараах зүйлсийн сүүдрийг зураарай.



Сүүдэр үүсгэхэд бие, гэрэл үүсгэгч хэрэгтэй юм байна. Гэрэл үүсгэгч байхгүй үед сүүдэр үүсэхгүй. Мөн бие байхгүй байхад сүүдэр үүсэхгүй байна. Гэрэл үүсгэгчээс гарч байгаа гэрлийн замд ямар нэг бие тавихад сүүдэр үүснэ.

## ГЭРЭЛ БА СҮҮДЭР

### ГЭРЭЛТЭЙ БА СҮҮДЭРТЭЙ ГАЗРЫН ЯЛГААГ СУДАЛЦГААЯ



Халуун өдөр амьтад яагаад сүүдэр газар хэвтэх дуртай вэ?



Ямар ялгаа байгааг судальяа.



- Юу ажиглах вэ?
- Юу хэрэгтэй вэ?
- Юу хийх вэ?

- Ямар үр дүнд хүрэх вэ?
- Аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ?



#### Туршилт 1



Би даарч байна.      Би халууцаж байна.

#### Туршилт 2

Хоёр саванд ижил хэмжээтэй ус хийнэ. Нэг савтай усаа нартай газар, нөгөөг нь сүүдэртэй газар тавина. 15-20 минутын дараа савтай усанд гарваа дүрээд үзээрэй. Ямар өөрчлөлт гарсныг ажиглаад тайлбарлаарай.



Нар бол хүүхэд та бүхэнд үргэлж харагдаж байдаг байгалийн нэг бие юм. Нарнаас асар их гэрэл дулаан ирж байдаг. Сүүдэр газар сэргүүн байдаг.

## ТЕРМОМЕТРИЙН ЗААЛТЫГ УНШИЖ СУРЦГААЯ




Халуун ба хүйтний ялгааг мэдэж болох уу?



Аль нь халуун, хүйтэн байгааг мэдэхийн тулд термометр гэдэг багажийг ашигладаг. Маш олон төрлийн термометр байдаг. Термометрийн заалтыг уншихдаа улаан зураас аль тоонд ойрхон байна. Тэр тоог термометрийн заалт болгон авдаг.

Термометрийн заалтыг уншихдаа дараах зүйлийг сайтар анхаараарай.




Зөв барьж  
харах




Булцуунаас  
барьж  
боловхгүй



Газар ухаж  
боловхгүй



Унагаж  
боловхгүй



Заалтыг уншихдаа эгц  
урдаас нь харж уншаарай.



### Туршилт 1

- Хар ба цагаан өнгийн цаасыг цонхон дээр наана. 15 минутын дараа цаасан дээр гарaa тавиад үзээрэй. Ялгаа байна уу?
- Хар ба цагаан өнгийн уутанд термометрээ хийж нартай үед цонхон дээр байрлуулна.
- Термометрийн заалтыг 15 минутын дараа тэмдэглэн аваарай.
- Ямар дүгнэлт хийж болох вэ?



### Туршилт 2

Нэг термометрээ сүүдэр газар, нөгөө термометрээ нартай газар тавиарай. 10 минутын дараа хоёр термометрийн заалт ижил байх уу?

- Таамаглал дэвшүүлээрэй.
- Термометрийн заалтыг харж харьцуулаарай.
- Дэвшүүлсэн таамаглал чинь зөв байна уу?



## ӨДӨР ХЭР УРТ ВЭ?



9 дүгээр сард хичээл эхэлснээс хойш намар, өвөл өнгөрч хавар эхэлж байна. Нар мандах ба жаргах цаг дандаа ижилхэн байсан уу? Өөр өөр байсан уу? Одоо ямар байгаа вэ?



Өдөр ба шөнийн уртыг судалцгаая. Зуны өглөө 6 цагт нар хэдийнээ мандаж өдөр эхэлсэн байдаг. Харин өвлийн өглөө 6 цагт ямар байдаг бэ? Ярилцаарай.



**Дасгал 1.** Зураг дээр зун ба өвөл нар мандах цагийг үзүүлжээ. Аль нь зуны улиралд, аль нь өвлийн улиралд тохирох вэ?



Ярилцаад дараах өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Зун .....цагт нар мандаж, 20 цагийн үед жаргадаг. Өвөл нар .....цагт мандаж, 18 цагийн үед жаргадаг.

**Дасгал 2.** Дээрх өгүүлбэрт өгөгдсөн нар мандах ба жаргах хугацааг ашиглан өдрийн үргэлжлэх хугацааг олж хүснэгтэд бичээрэй. Зун ба өвлийн алинд нь өдөр урт үргэлжилдэг вэ? “Урт”, “Богино” гэсэн үгний аль тохирохыг нь бичээрэй.

Улирал	Өдрийн үргэлжлэх хугацаа	Өдөр урт, богино аль нь вэ?
Зун		
Өвөл		



Нар мандахаас эхлээд нар жаргах хүртэл хугацааг өдөр гэж үздэг. Өдрийн үргэлжлэх хугацаа байнга өөрчлөгднө. Зуны улиралд нар өглөө эрт мандаж орой жаргана. Иймд зун өдөр урт байдаг. Өвлийн улиралд нар орой мандаж эрт жаргана. Иймд өвөл өдөр богино байдаг.

**Дасгал 3.** Өглөө нар мандаж байгааг дараах хоёр зурагт үзүүлжээ. Зургийг харьцуулан ажиглаарай. Аль нь зуны улирал, аль нь өвлийн улирал вэ? Зун ба өвлийг ямар шинж тэмдгээр хэрхэн ялгаж байгаага ярилцаарай. Өвөл ба зуны шинж тэмдгийг хоёр эгнээ болгон ялгаж бичээрэй.




Улирал	Зун	Өвөл
Шинж тэмдэг		

**Дасгал 4.** Зуны ба өвлийн орой нар жаргасны дараах хоёр зургийг ажиглаад харьцуулаарай.

А. Хэдэн цагт ийм байж болох вэ? Ярилцаад цэгийн оронд цагийг нөхөж бичээрэй.

Улирал .....

Улирал .....



Б. Өдрийн үргэлжлэх хугацаа улирлаас хамаардаг талаар юу мэдэж авсан бэ? Өгүүлбэрийг анхааралтай уншаарай. Хаалтан дотор байгаа улирлын аль нь тохирох вэ? Доогуур нь зураарай.

Аав, ээж нар мандсан хойно ажилдаа явдаг. (Өвөл, зун).

Хүмүүс нартай байхад ажлаасаа ирдэг. (Өвөл, зун).

Хүмүүс нар гараагүй байхад босож ажилдаа явна. (Өвөл, зун).

Аав, ээж нар жаргаж бүрэнхий болоход ажлаасаа ирдэг. (Өвөл, зун).

## ӨДӨР БА ШӨНӨ

### ӨДӨР, ШӨНӨ БА УРГАМАЛ



Хүүхдүүд ээ! Та нар өмнөх бүлэгт тасалгааны ургамлыг гэрэлсэг, гэрэлд дуртай, сүүдэрт дуртай, сүүдэрт тэсвэртэй гэж ангилаад хаана байрлуулах талаар ярилцаарай. Яагаад ургамлыг өөр өөр газар байрлуулсан бэ?



Ургамалд гэрэл хэрхэн нөлөөлдөг, ургамалд гэрэл яагаад хэрэгтэй болохыг хамтран судалцгаая.

#### БЭЛТГЭХ ЗҮЙЛ

- Тасалгааны ургамал
- Гялгар уут



**Дасгал 1.** Гэрэл ургамлын гадаад хэлбэр дүрсэд хэрхэн нөлөөлснийг ажиглаарай. Ямар зүйл ажигласнаа ярилцаарай.

Ургамлын онцлог	Хангалттай гэрэлтэй үед	Гэрэл дутагдсан үед
Гэрэлсэг ургамал		

Ихэнх ургамалд гэрэл хэрэгтэй. Ногоон ургамал нарны гэрлийн нөлөөгөөр өөртөө идэх хоолоо бэлтгэдэг. Энэ тухай бид дараагийн ангиудад дэлгэрэнгүй судлах болно. Харин одоо дараах туршилтыг хийгээд дүгнэлт гаргаарай.



#### Туршилт 1

1. Тасалгааны ургамлын хэсэг навчийг гялгар уутаар бүрхэж гэрэлд тавиарай (Гэхдээ уутыг навчны гадаргууд хүргэхгүй хөндий байлгана).
2. Гялгар уутан дотор ямар өөрчлөлт гарах бол таамаглаж ярилцаарай.
3. Нэг хоногийн дараа гарсан үр дүнг ажиглана.
4. Та нарын таамаглал үр дүнтэй тохирч байна уу?

**Дасгал 2.** Ургамал гэрлийн нөлөөгөөр хөдөлдөг гэдэгтэй санал нийлэх үү?

- a. Тийм                          b. Үгүй

**Дасгал 3.** Ургамлын аль хэсгээр ус ууршдаг вэ?

- a. Иш                                  b. Навч                                  c. Үндэс



Өдөр шөнийн урт, богино болон нарны гэрэл ургамлын ургах байдалд нөлөөлнө.

## ӨДӨР, ШӨНӨ БА АМЬТАН



Ургамалд гэрэл хэрэгтэй харин амьтанд гэрэл хэрэгтэй байдаг болов уу?



Зарим амьтад өдрийн цагаар хоол тэжээлээ олж иддэг байхад шөнийн цагаар идэш тэжээлээ эрж хайдаг онцлогтой амьтад бас байдаг.



Өдөр, шөнийн амьдралтай амьтад ямар ялгаатай болохыг судалцаая.

Амьтан

Өдрийн

Шөнийн



**Дасгал 1.** Өдөр, шөнийн амьдралтай, өөрийн сайн мэддэг амьтдын тухай багштайгаа болон ангийн найзуудтайгаа ярилцаарай.

- Тэд хаана амьдардаг тухай .....
- Юугаар хооллодог тухай .....
- Хоол тэжээлээ яаж барьж иддэг тухай .....

### Дасгал 2

1. Загас өдөр ч, шөнө ч нүдээ аньдаггүй. Яагаад вэ?
2. Сарьсан багваахай харанхуйд нисэж явахдаа шавжийг барьж иддэг. Хэрэв та нар анхааралтай ажигласан бол тэдний нүд бараг байхгүй гэж хэлмээр жижиг байдаг. Гэсэн хэдий ч тэд зүг чигээ маш сайн олж харанхуйд тийм жижиг шавжийг яаж олж барьдаг вэ?
3. Шөнийн эрвээхэй сарьсан багваахайнаас зугтаж нэг бол модонд наалдаж, эсвэл өөрийгөө хамгаалахын тулд үхсэн юм шиг дүр эсгэж чаддаг. Яаж мэддэг вэ?
4. Муурын нүдний хүүхэн хараа нь өдрийн цагт нарийссан байхад шөнийн цагт өргөсч харах талбайгаа ихэсгэдэг. Яагаад вэ?



Зарим амьтад өдрийн, зарим нь шөнийн идэвхтэй амьдралтай тул тэд амьдрах орчиндоо зохицсон байдаг.

## САР ХЭД ХОНОГТОЙ ВЭ?



Агар зандан мод  
Арван хоёр мөчиртэй  
Мөчир бүр нь гучин навчтай  
Навчны дээд тал нь шар  
Доод тал нь хар  
Тэр юу вэ?

Жил, сар,  
өдөр, шөнө



Онъсогоны талаар бүгдээрээ хамтран ярилцаарай.

- Онъсогот гарсан агар зандан мод гэж юуг хэлсэн бэ?
- Арван хоёр мөчир нь юуг төлөөлсөн бэ?
- Мөчир бүр нь гучин навчтай гэдэг нь ямар утгатай вэ?
- Навчны дээд тал нь шар, доод тал нь хар гэж хэлсэн нь ямар учиртай вэ?




**Дасгал 1.** Өдөр ба шөнө нийлээд хоног болно. Нэг хоног 24 цагтай тэнцэнэ.

- Жилд 12 сар байдаг. 12 сарыг дугаарлан эхнээс нь жагсаан бичээрэй.
- Чи хэдэн сард төрсөн бэ?
- Ангиараа хамтраад хэн нь хэдэн сард төрснийг нэмж бичээрэй.

Сар	Төрсөн хүүхдийн нэр	Хүүхдийн тоо
Нэгдүгээр сар	Хулан, Болд	2
Хоёрдугаар сар	Тэлмэн, Анар, Гангаа, Долгор	4
.....	.....	.....


Хүснэгт дэх мэдээллийг ашиглан диаграммаар илэрхийлээрэй.

Хүүхдийн тоо



**Дасгал 2.** Сар бүр хэд хоногтой болохыг багштайгаа хамтран тоолоорой.

- Хоёр гарсаа атгаад зэрэгцүүлж тавиарай.
- Гарынхаа чигчий хуруунаас эхлэн зураг дээр үзүүлсэн байдлаар саруудыг дэс дараалан тоолоорой.
- Хурууны үе дээр оногдох сарууд 31 хоногтой.
- Үений хооронд оногдох сарууд 30 хоногтой байдаг (хоёрдугаар сар 28 эсвэл 29 хоногтой).
- Тоолж үзээд хүснэгтийг нөхөөрэй.



Сарууд тоогоор	Нэр	Хоногийн тоо
1	Нэгдүгээр сар	
2	Хоёрдугаар сар	
3	Гуравдугаар сар	
4	Дөрөвдүгээр сар	
5	Тавдугаар сар	
6	Зургадугаар сар	
7	Долодугаар сар	
8	Наймдугаар сар	
9	Есдүгээр сар	
10	Аравдугаар сар	
11	Арван нэгдүгээр сар	
12	Арван хоёрдугаар сар	

## САР БА УЛИРАЛ

### УЛИРЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ



Хавар, зун, намар, өвлийн улирал тус бүрд хэд хэддүгээр сар хамарагддаг вэ?

- Байгаль ба хүмүүсийн амьдралд улирал, сараар ямар өөрчлөлт гардаг вэ?



Зургийг ажиглаарай.



- Хаврын улиралд хэддүгээр сарууд багтдаг вэ?
- Хавар ямар ямар үйл явдал болдог вэ?
- Хүмүүс хавар ямар ажил хийдэг вэ?



- Зуны улиралд хэддүгээр сарууд багтдаг вэ?
- Зун ямар ямар үйл явдал болдог вэ?
- Хүмүүс зун ямар ажил хийдэг вэ?



- Намрын улиралд хэддүгээр сарууд багтдаг вэ?
- Намар ямар ямар үйл явдал болдог вэ?
- Хүмүүс намар ямар ажил хийдэг вэ?



- Өвлийн улиралд хэддүгээр сарууд багтдаг вэ?
- Өвөл ямар ямар үйл явдал болдог вэ?
- Хүмүүс өвөл ямар ажил хийдэг вэ?



**Дасгал 1.** Зураг дээр үзүүлсэн үйл явдлын талаар ярилцаарай. Эдгээр үйл явдал хэддүгээр сард болдог бэ?

Хоёрдугаар сар

Хаврын  
улирал


Дөрөвдүгээр сар

Гуравдугаар сар





Намар ямар үйл явдал болдог вэ? Зургийг ажиглаад ярилцаарай.



Өвлийн улиралд байгаль, хүмүүсийн амьдралд ямар өөрчлөлт гардаг вэ?  
Сар бүрд тохирох зургийг дэвтэртээ сонгож зураарай.



## САР БА УЛИРАЛ

### УЛИРЛЫН ҮЗЭГДЭЛ БА УРГАМАЛ



Жилийн 4 улиралд ургамлын амьдралд ямар өөрчлөлт гардаг вэ? Ажигласнаа дараах хүснэгтэд тэмдэглээрэй.

Хавар	Зун	Намар	Өвөл



Ургамлыг бид хоол хүнсэнд хэрэглэхээс гадна тэд бас бидний амьсгалах агаарыг бэлэглэж байдаг ачтан. Иймээс ургамлыг улирлын онцлогоос хамааран хамгаалах ажлыг зохион байгуулахад оролцьё.

Юу хийх вэ?

Хавар мод, сөөг тарих,  
үр суулгах зэрэг  
тариалалтын бэлтгэл  
ажил хийхэд  
тохиромжтой.



Зуны дэлгэр цагт мөд  
ургамал ид цэцэглэж, үр  
жимсээ өгдөг. Иймээс  
шалтгаангүйгээр  
ургамал тасдаж  
боловхгүй.



Ургамал өвлийн  
улиралд тайван  
байдалд ордог. Энэ  
үед ургамлыг зөв  
хамгаалах ажил хийх  
хэрэгтэй.



Нарны илч,  
гэрэл багасахад  
навчинд очих  
чийгийн хэмжээ  
дутагдаж навч  
шарлаж унадаг.  
Унасан навчийг цуглуулж  
шатаах бус бордоо болгож  
ашиглаж болно шүү.





**Дасгал 1.** Хавар аав, ээж, ах, эгч нар мод тарихад бид яаж тусалж чадах вэ? Сургуулийн гадна талбайд гарч мод услахад оролцох төлөвлөгөө гаргаарай.

**Дасгал 2.** Өвлийн улиралд тасалгааны ургамлын усалгааг багасгадаг. Ямар сонголт хийснээ тайлбарлаарай.



a. Зөв

б. Буруу

Монгол орон цаг уурын эрс ялгагдах жилийн дөрвөн улиралтай. Жилийн дөрвөн улирлыг дагаж ургамал өөрчлөгддөг тул түүнд тохирсон арчилгаа хамгаалалт өөр өөр байдаг.

## УЛИРЛЫН ҮЗЭГДЭЛ БА АМЬТАН



Жилийн 4 улиралд амьтны амьдралд ямар өөрчлөлт гардаг вэ? Ажигласнаа дараах хүснэгтэд тэмдэглээрэй.

Хавар	Зун	Намар	Өвөл



Урин дулаан цагт бужигналдаж байсан шавж, шувуу, гүрвэл зэрэг амьтад хүйтэн сэргүүний улиралд харагдахаа больдог. Тэд хаачсан бэ?



- Ичсэн үү, нүүсэн үү? мөхсөн үү?
- Амьтад яагаад ичдэг вэ?
- Амьтад яагаад нүүдэллэдэг вэ? гэдгийг хамтран судалцгаая.



**Дасгал 1.** Тарвага, баавгай өвөл яагаад ичдэг вэ? Өвөл ичээнд ордог өөр ямар амьтдын тухай мэдэх вэ? Ярилцаарай.



**Дасгал 2.** Загийн шар аалз гэх мэт зарим амьтад хоногийн ичээнд ордог. Яагаад вэ?

**Дасгал 3.** Дараах зургийг хараад амьтад яагаад нүүдэл хийсэн талаар ярилцаарай.

Усны шувууд



Зуны дараа дулаан орон руу нүүдэллэдэг.

Зээр



Байгалийн гэнэтийн үзэгдлийн үед сүрэглэн нүүдэллэдэг.

Загас



Өвөл усны гүнд өвөлжөөд хавар олноороо нүүдэллэдэг.



Амьтад цаг агаарын тааламжгүй нөхцөл болон идэш тэжээл хомсдоход ичдэг. Уур амьсгал, амьдрах орчин нөхцөл өөрчлөгдөх буюу үржлийн үед амьтад нүүдэл хийдэг.

## АГААРЫН ХАЛУУН, ХҮЙТНИЙГ ХЭМЖИЖ СУРЬЯ



Би термометрийн заалтыг уншиж сурлаа.

Агаарын халуун, хүйтнийг хэмжиж туршья.



### Бэлтгэх зүйл

Аав, ээж, багшийн тусlamжтайгаар термометрийг гадаа байрлуулъя.




### Туршилт 1


1. Өглөө, өдөр, орой гурван удаа тогтсон цагт хэмжилт хийж заалтыг тэмдэглээрэй.
2. Хэзээ хамгийн халуун байсан бэ?
3. Хэзээ хамгийн сэргүүн байсан бэ?
4. Термометрээр халуун хүйтнийг хэмжихэд ямар хүндрэл учирсан бэ? Түүнийгээ чи хэрхэн шийдсэн бэ? Нөхдөдөө ярьж өгөөрэй.




**Дасгал 1.** Өглөө, өдөр, оройн заалтыг термометрт будаж тэмдэглээрэй.



Өглөө ----



Өдөр ----




Орой ----

**Дасгал 2.** Хамгийн их ба бага хоёр заалтын зөрүүг олоорой.

$$\boxed{?} - \boxed{?} = \boxed{?}$$

**Дасгал 3.** Дараах гурван термометрийн заалтыг ажиглан харьцуулаарай. Халуунаас нь хүйтэн рүү дараалуулан 1, 2, 3 гэсэн тоогоор тэмдэглээрэй.



## Туршилт 2

Таван өдрийн агаарын хэмийн өөрчлөлтийг ажиглаарай. Туршилтыг эцэг, эхтэйгээ хамтран хийгээрэй.

1. Аав, ээжийн тусламжтайгаар термометрийг гадаа байрлуулаарай.
2. Термометрийг эгц байрлуулсан эсэхээ шалгаарай.
3. Хэмжилтийг өдөр бүр тогтмол нэг цагт тэмдэглээрэй.
4. Таван өдрийн хэмжилтийн заалтыг харьцуулаарай.



Агаарын халуун хүйтнийг хэмжиж үзлээ.



Хүний биеийн халууныг хүйтнийг хэмжиж болох уу?

**Дасгал 4.** Энэ хоёр термометрээр биеийн халууныг хэрхэн хэмжих вэ? Аль нь халуурсан хүүхдийн биеийн халууныг зааж байна вэ?



Термометрийг хүчтэй сэгсэргч доргиож болохгүй. Мөн унагааж хагалахаас болгоомжлоорой!

## АЯЛАЛД ЯВАХ УУ?



Хэрвээ цаг агаар сайхан байвал бямба гарагт аялалд явцгаая.



Цаг агаар ямар байх бол? Үүнийг яж мэдэх вэ?



Манай өвөө тэнгэрийн байдлыг сайн шинждэг юм. Би өвөөгөөсөө асуугаад ирье.




Би зурагтаар цаг агаарын мэдээг сайн сонсоод та нарт хэлье.



Гэхдээ бид нар өөрсдөө ч цаг агаарыг ажиглаж болно шүү дээ.



**Дасгал 1.** Өдөр болгон 11-12 цагийн хооронд ажиглалтаа хийж тохирох дүрсийг хүснэгтэд наагаарай. Таван өдрийн цаг агаарыг тэмдэглэх дүрсээ зураад хайчилж бэлдээрэй.



**Дасгал 2.** Ажиглалтаа дуусаад дараах асуултад хариулан бичээрэй.

- А. Нартай өдөр хэд байсан бэ? \_\_\_\_\_
- Б. Үүлтэй өдөр хэд байсан бэ? \_\_\_\_\_
- В. Хэзээ салхи их байсан бэ? \_\_\_\_\_
- Г. Цаг агаар өдөр бүр ижил байсан уу? \_\_\_\_\_

**Дасгал 3.** Цаг агаарын ажиглалтаа тасралтгүй хийж, ажиглалтын хүснэгтээ үргэлжлүүлэн хөтлөөрэй.

Өдөр					
Цаг агаар					

**Дасгал 4.** Аялалд явахдаа ямар бэлтгэл хангах хэрэгтэй вэ? Зургийг ажиглаад аяны цүнхэндээ гурван зүйлийг сонгож хийнэ үү. Авч явах гурван зүйлээ цүнх рүү холбож зураарай.



**Дасгал 5.** Цаг агаарын онцлогт тохирох хувцсыг зөв харгалзуулаарай.

a.



1.



б.



2.



в.



3.



Цаг агаар өдөр бүр өөр байх бөгөөд байнга өөрчлөгднө. Цаг агаарын онцлогт тохируулан хувцсаа сонгож өмсөх нь эрүүл мэндээ хамгаалахад туслах болно.

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

### БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Харанхуйг гэрэлтүүлдэг зүйлсийг нэрлэнэ үү?

.....

2. Сүүдэр үүсгэхэд бидэнд юу хэрэгтэй вэ? Зургаас сонгож дугуйлаарай.



Асаалттай  
гар утас



Бөмбөг



Асаж байгаа  
бамбар



Асаж байгаа  
гар чийдэн






Асаж байгаа  
лаа

3. Гэрэлтэй ба сүүдэртэй газрын ялгааг бичээрэй.

Гэрэлтэй	Сүүдэртэй

4. Термометрийн заалтыг бичээрэй.




5. Өдрийн үргэлжлэх хугацааг тооцоолж, хүснэгтэд бичээрэй.

Улирал	Нар мандах хугацаа	Нар жаргах хугацаа	Өдрийн үргэлжлэх хугацаа	Аль улиралд өдөр урт үргэлжлэх вэ?
Зун	6 цаг	20 цаг		
Өвөл	8 цаг	18 цаг		

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

6. Өгөгдсөн зүйлтэй төсөөтэй биеүдийг нэмж зураарай.



7. 30 хоногтой саруудыг нэрлээрэй.
- .....

8. Жилийн хамгийн бага хоногтой сар нь хэддүгээр сар вэ?

Сар ..... Хоног нь .....


9. Тэмдэглэлт үйл явдлуудын нэрийг бичиж, ямар улиралд болдогийг нэрлээрэй.

Тэмдэглэлт өдөр	Хэзээ болдог вэ?	Ямар улиралд

10. Бороотой өдөр ууланд аялах бол юу авч явах хэрэгтэй вэ? Нэрлээрэй.
- .....
- .....
- .....

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

11. Зургийг ажиглаад улирлынх нь нэрийг тохируулан бичээрэй. Дөрвөн улирлын зурагт тайлбар Бичээрэй.



12. Асуултыг уншаад тохирох амьтны нэрийг бичээрэй.

Өвөл ичээнд ордог амьтдад: .....

Улирлын болон хоногийн ичээнд ордог амьтдад: .....

.....

13. Зургийг ажиглаад тайлбар бичээрэй.



.....

.....

## БҮЛГИЙН ҮНЭЛГЭЭ

14. Дараах зургийг ажиглаад хүүхдүүдийн хийж буй үйлийг зөв, буруу гэж ялгаарай. Буруу үйл хийж буй эздэд нь зориулж хэлэх үгээ сургамжит болон зүйр цэцэн үг ашиглаж бичээрэй.



# **ХҮН БА ОРЧИН**

## **||**

Ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн сурхад бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:

Гишүүд:

А.Энхтогтох

Е.Батчулуун

Г.Баярмаа

Ө.Болорчимэг

Э.Мөнгөнтулга

Р.Нямхүү

Т.Оюун

У.Туяа

М.Энхбаяр

Редактор:

Техник редактор:

Зураач:

Г.Цэцэгмаа

У.Мягмаржав

М.Агар

Х.Цэнгүүн

Н.Сонинбаяр

Д.Мөнхбаяр

Хэвлэлийн эх бэлтгэгч:

Формат 84x108/16  
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80 гр/м<sup>2</sup>  
Хэвлэлийн хуудас 8 х.х.

Хэвлэлийн эхийг “Битпресс” ХХК-д бэлтгэж,  
“Битпресс” ХХК-д 10800 хувь хэвлэв.



